


Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2024 оны 1 дүгээр сарын 31-ны өдрийн  
дугаар тушаалын зургаадугаар хавсралт



№ 2024-001-06

## УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН САНАЛ АВАХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИД ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

### Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл

1.1. Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Сонгуулийн тухай хууль, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, сонгуулийн санал авах байруудад төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж гал түймрийн эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, хяналт шалгалт хийх журам, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

### Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах барилга, байгууламжийг хамруулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

2.3. Гал түймрийн улсын хяналтын байцаагч нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулахаар захиргааны хэмжээний актыг хүргүүлнэ.

2.4. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.5. Хяналт шалгалтад хамрагдах объектын судалгааг гаргаж хяналт шалгалт зохион байгуулах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан газар, хэлтсийн даргаар батлуулан хуваарийн дагуу үр дүнтэй зохион байгуулна.

2.6. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга хариуцна.

Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд,  
барилга байгууламжийн нэр

3.1. Сонгуулийн ерөнхий хорооны байр;

3.2. Санал авах барилга байгууламж.

Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч,  
хугацаа

4.1. Нийслэлийн хяналт шалгалтын  
ажлын хэсгийн ахлагч

Гишүүд

Нийслэлийн Онцгой байдлын газрын  
Гал түймрийн улсын хяналтын ахлах  
байцаагч;

Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал  
түймрийн улсын хяналтын ахлах байцаагч,  
байцаагч нар;

4.2. Орон нутгийн хяналт шалгалтын  
ажлын хэсгийн ахлагч

Гишүүд

Төв орон нутгийн Онцгой байдлын газрын  
орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга;  
Төв орон нутгийн Онцгой байдлын газрын  
Гал түймрийн улсын хяналтын ахлах  
байцаагч, байцаагч нар.

4.3. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг сонгуулийн санал авах өдөр товлогдсоноос 1 сарын өмнө 1 сарын хугацаатай зохион байгуулна.

4.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн мэдээг сонгуулийн санал өдөр дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан хавсралт хүснэгтийн дагуу боловсруулж, гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудасны хамт Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн [inspector.obeg@gmail.com](mailto:inspector.obeg@gmail.com) цахим хаягаар ирүүлнэ.

4.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.



УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН САНАЛ АВАХ БАРИЛГА,  
БАЙГУУЛАМЖИД ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН МЭДЭЭНИЙ ХҮСНЭГТ

Хүснэгт 1

№	Аймгийн нэр	Хяналт шалгалтад хамрагдвал зохих объектын тоо	Хамрагдсан барилга байгууламжийн тоо	Илрүүлсэн зөрчлийн тоо	Газар дээр нь арилгуулсан зөрчлийн тоо	Хүргүүлсэн баримт бичгийн тоо			Зөвлөмж
						ЗБАШ	Мэдэгдэл	Танилцуулга	
1									
2									

ТАНИЛЦСАН

АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,

...../...../

/цол/

/гарын үсэг/

МЭДЭЭ НЭГТГЭСЭН.

АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГТУХБ,

...../...../

/цол/

/гарын үсэг/